



2014.06.25

ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Геодези, зураг зүйн салбарыг хөгжүүлэхэд хүч чадал, оюун ухаан, эрдэм мэдлэг, авьяас билэг, идэвхи санаачлага гарган, үр бүтээлтэй ажиллаж, онцгой амжилт гаргасан ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулахад энэхүү журмыг дагаж мөрднө.

1.2. Геодези, зураг зүйн салбарын инженер техникийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх үйлсэд идэвхи зүтгэл гарган бодитой хувь нэмэр оруулсан бусад байгууллагын албан хаагч, гадаадын иргэнийг 2.1-д заасан шагналаар шагнаж болно.

Хоёр. ШАГНАЛЫН ТӨРӨЛ

2.1. Геодези, зураг зүйн салбарын шагнал нь дор дурдсан төрөлтэй байна.

2.1.1. Геодези, зураг зүйн салбарын "Хүндэт тэмдэг"

2.1.2. Геодези, фотограмметр, зураг зүйн холбооны "Хүндэт дэвтэр"-т бичиж, дурсгалын гэрчилгээ олгох

2.1.3. Геодези, зураг зүйн холбооны жуух бичиг

Гурав. ШАГНАЛЫГ МЭДҮҮЛЭХ

3.1. Тус журмын 2.1.1-т заасан шагналыг холбооны олон нийт, дотоод үйл ажиллагааны зөвлөл шагнуулах үндэслэлийг тодорхой бичиж, ажлын үзүүлэлт, судалгаа, тооцоогоор баталгаажуулан, нээлт бүтээлийн жагсаалтыг хуулбарлан хавсаргана. Тус зөвлөл мөн 3.2.1-3.2.7-д заасан материалыудыг бүрдүүлэн холбоонд хандана.

3.2. Тус журмын 2.1.2, 2.1.3-т заасан шагнуулах саналыг тухайн байгууллагын удирдлагын болон нийт хамт олны хурлаар хэлэлцэх ба шагнуулах үндэслэлийг тодорхой бичиж, ажлын үзүүлэлт, судалгаа, тооцоогоор баталгаажуулан, нээлт бүтээлийн жагсаалтыг хуулбарлан хавсаргана. Дараах материалыудыг бүрдүүлж холбоонд хандана.

3.2.1. Тухайн байгууллагын албан бичиг

3.2.2. Шагналд нэр дэвшүүлсэн хүний анкет, үндэслэл, фото зураг

3.2.3. Хамт олны хурлын протокол

3.2.4. Тухайн хүний ажил байдлын тодорхойлолт, бүтээлийн жагсаалт

3.2.5. Шагналд тодорхойлж буй хүнийг МГФ33Х-ны шагнагдах шийдвэр гарсны дараа тухайн байгууллагаас үндсэн цалинтай тэнцэхүйц болон дүйцэхүйц шагнал урамшуулал олгохыг зөвшөөрсөн захирлын тушаал

3.2.6. Нийгмийн даатгалын дэвтрэйн хуулбар

3.2.7. Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар

3.3. МГФ33Х-ны шагналаар Монгол Улсад ажиллаж буй гадаадын иргэнийг шагналд тодорхойлж болох бөгөөд дээрхи журмын дагуу материал бүрдүүлнэ.

3.4. Өмнө шагнагдсан шагналаас хойш 3-аас доошгүй жил тогтвортой ажиллаж, ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшнээс ахисан нэхцэлд дараагийн шатны шагналд нэр дэвшүүлнэ.

3.5. Шагналд нэр дэвшүүлж буй хүний бүрдэл болсон материалыг хүлээн авснаар МГФ33Х тухайн хүний өмнө ямар нэг үүрэг хүлээхгүй.

3.6. Шагналд нэр дэвшигчийн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд шагнал олгохгүй.

Дөрөв. ШАГНАЛ ОЛГОХ БОЛЗОЛ

4.1. Энэхүү журмын 2.1.1, 2.1.2, 2.1.3-т заасан шагналыг шат дараалан, давхардуулахгүй олгоно. 2.1.1-д заасан шагналыг жилд 3 хүнд олгоно. Улс, олон улсын хэмжээнд онцгой амжилт гаргасан тохиолдолд холбооны удирдах зөвлөлийн шийдвэрээр болзول харгалзахгүй олгож болно.

4.2. МГФ33Х-ны цол тэмдэг, жуух бичгээр салбартай үнэтэй хувь нэмэр оруулсан, ажлын өндөр амжилт бүтээл гаргасан тэргүүний хүмүүсийг шагнахад энэ журмыг мөрднө. МГФ33Х-ны шагналыг хүртэгсэд нь холбооны болон салбарын нэр хүндийг өндөрт өргөж, олон талт ажлын

Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо

эн тэргүүн эгнээнд явах хошуучлагч байх төдийгүй залуу үеийнхний бахархал, үлгэр дууриалал болон ажилласан байна.

4.3. Салбарын “Хүндэт тэмдэг” -ээр Геодези, зураг зүйн салбарыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан, гаргасан амжилт бүтээл нь салбартай үнэлэгдсэн, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажилд нээлт, ололт гаргасан, бусдыг манлайлсан, өндөр ур чадвартай ажилтан, албан хаагчдаас жилд нэг удаа шалгаруулж 1 хүнийг шагнана. “Хүндэт тэмдэг” шагналыг дагалдах мөнгөн шагнал 2000000 (Хоёр сая) төгрөг байна.

4.4. Геодези, зураг зүйн салбарыг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан, 10-аас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажилд нээлт, ололт гаргасан тэргүүний ажилтан, албан хаагчыг МГФЗ3Х-ны “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь бичиж, дурсгалын гэрчилгээ олгоно.

4.4.1. “Хүндэт дэвтэр”-т бичүүлэх ажилтан, албан хаагчын 6х9 см-ийн хэмжээтэй фото зургийг тус дэвтэрт байрлуулж, овог нэр, хөдөлмөр бүтээлийн амжилтыг дурдсан товч тодорхойлолт, гаргасан шийдвэрийн дугаар, огоонг бичнэ.

4.5. Геодези, зураг зүйн салбарт 7-оос доошгүй жил санаачлага, үр бүтээлтэй ажиллаж, ажил үйлсээрээ тэргүүлж тодорхой бүтээл гаргасан ажилтан, албан хаагчыг МГФЗ3Х-ны “Хүндэт жуух бичиг”-ээр шагнана.

Тав. ШАГНАЛ ОЛГОХ

5.1. МГФЗ3Х-ны гүйцэтгэх захирал шагнуулахаар ирүүлсэн, холбогдох баримт бичгийн бүрдэл, агуулгыг судлан, санал боловсруулж, шийдвэрийн төслийг тус холбооны удирдах зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлнэ.

5.2. Тус журмын 2.1.1, 2.1.2, 2.1.3-т заасан шагналаар шагнуулсан ажилтан, албан хаагч нь тэмдэг, гэрчилгээ, үнэмлэхийг үргэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд тухайн ажилтан, албан хаагчын ажиллаж буй байгууллагын тодорхойлолт, өөрийн өргөдөл, үрэгдүүлсэн тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлуулсан тухай баримтыг үндэслэн үнийг нь төлүүлж нэг удаа солих буюу нөхөн олгож болно.

Зургаа. ШАГНАЛД ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГӨ

6.1. Тус журмын 2.1.1, 2.1.2, 2.1.3-т заасан шагналаар шагнуулсан ажилтан, албан хаагчын шагналын дагалдах мөнгөн шагналыг шагналд нэр дэвшүүлэгч байгууллага хариуцна.

6.2. Тус журмын 2.1.1, 2.1.2, 2.1.3-т заасан шагналаар шагнуулсан гадаадын иргэнд мөнгөн шагнал дагалдахгүй.

Долоо. ШАГНАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САН

7.1. МГФЗ3Х нь шагналын цахим мэдээллийн сантай байх ба тус санг шагналын төрөл, орон нутаг, байгууллага, оноор төрөлжүүлэн бүрдүүлнэ.

7.2. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт, хөдөлгөөнийг МГФЗ3Х-ны гүйцэтгэх захирал хариуцна.

Найм. БУСАД

8.1. Тус журмын 2.1.1, 2.1.2, 2.1.3-т заасан шагналын тэмдэг, үнэмлэхний загварыг МГФЗ3Х-ны тэргүүний тушаалаар батална.

8.2. Гадаадын иргэнд олгох шагналын үнэмлэх, гэрчилгээ англи хэл дээр байна.